

ТАНИЛЦУУЛГА

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Хуулийн төслийн зорилт нь хуульчийн мэргэжлийн шалгалт, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, хуульчийн эрх зүйн байдал, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төслийн нийтлэг үндэслэлийг тодорхойлсон **нэгдүгээр бүлэгт** хуулийн зорилт, хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлсон.

Энэхүү бүлэгт тодорхойлсноор "хуульч" гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хүнийг, "хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа" гэж шүүгч, прокуророор ажиллах, нотариатчийн, өмгөөллийн болон хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааг тус тус ойлгохоор тусгаж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд нотариатчийн үйл ажиллагааг нэмж тусгасан.

Хуулийн төслийн **хоёрдугаар бүлэгт** хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шалгалт, түүнийг зохион байгуулах, хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох ажил, хуульчийн шалгалтад орох тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх болон хуульчийн шалгалтад оруулахаас татгалзсан шийдвэрт гомдол гаргах зэрэг хуульчийн шалгалттай холбогдсон харилцааг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуультай ижил, төстэй байдлаар зохицуулахаар тусгасан.

Хуулийн төсөлд туссан зарчмын шинжтэй өөрчлөлт нь энэхүү бүлэгт туссан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар эрх зүйн дээд боловсрол эзэмшсэн, 2 жилээс багагүй хугацаанд мэргэжлийн дадлага хийсэн хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй байх тухай зохицуулалтыг хэвээр хадгалж, нэмж "хуульчийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх" шаардлагыг тогтоосон. Ингэснээр эрх зүйн дээд боловсролтой хэн боловч хуульч болохыг хүсвэл энэхүү сургалтад заавал хамрагдах, энэхүү сургалтын агуулга, хэлбэрийг Хуульчдын холбоо хууль зүйн сургуулийн магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх замаар тодорхойлох, хууль зүйн боловсрол, хуульчдын мэргэжил, ур чадварт эерэгээр нөлөөлнө гэж үзсэн.

Мөн энэхүү зохицуулалтаас гадна хуульчийн шалгалт сорилгын болон бодлогын хэсгээс бүрддэг байсныг өөрчилж, шаардлагатай тохиолдолд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хандлага, дадал тогтсон эсэхийг шалгах хэсгийг нэмж тусгасан. Түүнчлэн хуульчийн шалгалтыг нэг жил нэг удаа авдаг байсныг өөрчилж, жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна гэж зохицуулсан бөгөөд энэ нь шалгалтын зохион байгуулах үйл ажиллагаа болон шалгалтад оролцогчдын ачааллыг жигд хуваарилах, түүнийг бууруулах чухал ач холбогдолтой.

Гуравдугаар бүлэгт хуульчийн зөвшөөрөл, түүнийг олгох журам, хуульч мэргэжлийн нэрийг хэрэглэх эрх, хуульчийн зөвшөөрөл олгох ажиллагааг түдгэлзүүлэх, хуульчийн зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл, хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгох талаархи харилцааг зохицуулсан.

Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн ерөнхий зарчмыг хэвээр хадгалсан бөгөөд хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх тохиолдлыг цөөлж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд заасан “өөрөө хүсэлт гаргасан” гэсэн үндэслэлийг хуулийн төслөөс хасаж, хуулийн зарим зохицуулалтыг илүү боловсронгуй болгосон.

Хуулийн төслийн **дөрөвдүгээр бүлэгт** хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл, хуульчийн эрх, үүрэг, тангараг, түүнд хориглох зүйл, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрмийн талаархи зохицуулалтыг тусгалаа.

Энэ бүлэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа нь шүүгч, прокуророор ажиллах, өмгөөллийн, нотариатчийн болон хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх төрөлтэй байхаар тусгаж, шүүгч, прокуророор ажиллах болон өмгөөллийн, нотариатчийн үйл ажиллагаа эрхлэх журмыг холбогдох хуулиар, хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх журмыг энэ хуулиар зохицуулахаар тусгасан.

Энэ бүлэгт хуульч эрхэлж байгаа мэргэжлийн үйл ажиллагааны төрлөөс үл хамааран эдлэх эрх, хүлээх үүрэг, түүнд хориглох зүйлийг нийтлэг байдлаар тодорхойлсон бөгөөд нийтлэг ёс зүйн дүрэмтэй байхаар тусгасан.

Түүнчлэн энэхүү бүлэгт мэргэшсэн хуульч, мэргэшсэн хуульчид тооцох, түүнд тавигдах шаардлагыг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн жил, ажилласан туршлагаас хамаарахаар зааж, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны төрөл, тэдгээрийг эрхлэх нөхцөл, журмыг тодорхойлсон.

Тавдугаар бүлэгт хуульчийн сургалт, түүний төрөл, сургалтыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан. Энэ бүлэгт зааснаар хуульчийн сургалт нь мэргэшүүлэх болон үргэлжилсэн сургалтын хэлбэртэй байх бөгөөд бөгөөд хуульчийн үргэлжилсэн сургалтыг Хуульчдын холбоо зохион байгуулахаар тусгасан.

Хуулийн төслийн **зургадугаар бүлэгт** хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нэг төрөл болох хуулийн зөвлөхийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан. Хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу “бусад хуульч” гэж нэрлэгдэж байгаа шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажилладаггүй хуульч нарын эрх зүйн байдлыг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийн уг бүлгийн зохицуулалтыг илүү дэлгэрэнгүй тодорхой болгож бие даасан бүлэгт зохицуулсан бөгөөд энэхүү бүлгийн зохицуулалтад “бусад хуульч” нар болон хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа шүүгч, прокурор, өмгөөлөгч бус хуульч нарын үйл ажиллагаа хамаарна.

Хуулийн төслийн **долдугаар бүлэгт** Хуульчдын холбооны эрх зүйн байдал, түүний чиг үүргийн хороодын талаархи зохицуулалтыг тусгасан. Ингэхдээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн энэ талаархи ерөнхий зарчмыг хадгалах

бөгөөд чиг үүргийн хороодын бүрэлдэхүүн, ажиллах журам, дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, Их Хурал, Зөвлөлийн эрх, үүрэгтэй холбогдсон зохицуулалтыг илүү боловсронгуй болгоно. Тухайлбал, Зөвлөл болон чиг үүргийн хороод дахь хуульчдын төлөөллийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл тус бүрийн төлөөллийг тэнцүү байхаар зохицуулж, Их Хурлыг ээлжит хуралдааныг Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаатай уялдуулсан. Хуулийн төслийн энэхүү бүлэгт чиг үүргийн хороодын ажиллах журмыг илүү нарийвчлан зохицуулсан.

Хуульчдын холбооноос зарим чиг үүргээ буюу хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх, бодлогын нөлөөлөл хийх, шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх зэрэг чиг үүргээ хэрэгжүүлэх журмыг энэхүү бүлэгт тусгасан. Ингэхдээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид заасан тодорхойгүй, практикт хэрэгжих боломжгүй зохицуулалтуудыг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаанд үндэслэн засаж, сайжруулсан.

Хуулийн төслийн **наймдугаар бүлэгт** хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүнийг хүлээлгэх журмыг нарийвчлан зохицуулсан. Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахдаа одоо хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам, маргаан хянан шийдвэрлэх журмын зохицуулалтыг үндэслэл болгон авч үзсэн. Хуулийн төслийн үзэл баримтлалд заасан хариуцлага хүлээлгэх тогтолцооны давхардлыг арилгах зорилгоор шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчын мэргэжлийн ёс зүйн зөрчилтэй холбоотой маргааны асуудлаар иргэн, хуулийн этгээдээс хандсан тохиолдолд Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо дүгнэлт гаргаж, холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх эрх бүхий субъектэд нь хүргүүлдэг байх, хуулийн зөвлөхөд холбогдох маргааныг өөрөө эцэслэн хянан шийдвэрлэдэг байх, шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчид холбогдох хуульд хуульчийн гэрчилгээг хүчингүй болгохоор тусгайлан заасан асуудлаар энэхүү хариуцлагыг хүлээлгэдэг байхаар зохицуулалтыг боловсруулсан.

Хуулийн төслийн **есдүгээр бүлэгт** Хуульчдын холбооны бие даасан байдлыг хангах баталгаа, Хуульчдын холбооноос хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харилцах, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаагийн хувьд ажлаа тайлагнах журмыг тусгасан.